**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР**
**ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 09 сарын 09 өдөр Дугаар 85 Хэрлэн сум

Х.Болоргэрэлийг төрийн жинхэнэ
албаны нөөцөд бүртгэх тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.1.1, 46.6 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам"-ын 2.1.4, 3.1.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хүн ам зүйн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн бодлого хариуцсан мэргэжилтэн Хатанбаатарын Болоргэрэл нь эрүүл мэндийн шалтгаанаар төрийн албанаас түр чөлөөлөгдсөн тул төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэсүгэй.

2. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын дагуу Х.Болоргэрэлийг нөөцийн бүртгэлд бүртгэхийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Ж.Саруултөгс)-д даалгасугай.

ДАРГА Ж.ГАНТУЛГА

Төрийн албаны зөвлөлийн
Хэнтий аймаг дахь салбар
зөвлөлд хүсэлт гаргах нь

2024.08.02

Миний бие Хатанбаатарын Болортэрэл нь 2013 оны 11 дүгээр сард төрийн албан хаагчийн шалгалт өгч тэнцэж 2014 оны 10 дугаар сарын 24-нд төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөсөн.

2013 оны 2 дугаар сараас 2018 оны 04 дүгээр сар хүртэл хугацаанд төрийн албан хаагчаар ажиллаж байгаад удаан хугацаагаар эмчлүүлэх шаардлагатай бол тул 2018 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр төрийн албанаас эрүүл мэндийн шалтгаанаар түр чөлөөлөгдсөн.

Одоо төрийн албанд эргэн ажиллах хүсэлтэй байгаа тул төрийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн албан хаагчийн болон иргэний нөөцөд бүртгэж өгнө үү.

Холбогдох материалын хуулбарыг хавсаргав.

Хүсэлт гаргасан
Х.Болортэрэл
РД: ЦР81101802
Утас дугаар 99299047

# УДИРДАХ АЖИЛТНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС

Оролцогчийн: ................................ /ургийн овог/
Хатанбаатар .......... /эцэг буюу эхийн нэр/ зураг 4х6
Болоргэрэл .............. /нэр/
ЧР 81101802 ........ /регистрийн дугаар/

Ажиллахыг сонирхож буй:
Байгууллага: СХД-ийн ЗДТГ
Нэгж: Худалдаа үйлчилгээний хэлтэс
Албан тушаал: Хэлтсийн дарга
Албан тушаалын:
ангилал: ТЗ
зэрэглэл: 7

| Шалгалтын төрөл | Шалгалт өгсөн огноо | Авбал зохих оноо | Авсан оноо |
|---|---|---|---|
| 1. Ерөнхий шаардлага /боловсрол, туршлага, мэргэшсэн байдал/-ын оноо | 2013.11.13 | 35 | 13,48 |
| 2. Удирдах ур чадвар /сорил, бичгийн болон мэдээллийн технологи/-ын оноо | 2013.11.13 | 40 | 25,0 |
| 3. Ярилцлагын оноо | 2013.11.14 | 25 | 23,0 |
| нийт оноо | 2013.11.14 | 100 | 61,48 |

дүнтэй танилцсан: ....................................
огноо 2013.11

Сонгон шалгаруулах комиссын:
Дарга: ................................................ /С.Отгонгэрэл/
/тэмдэг/ /гарын үсэг/
Нарийн бичгийн дарга: ........................ /Д.Алтанцэцэг/
/гарын үсэг/

22

2013 оны 11 сарын 14-ны өдөр

| Ерөнхий шаардлагын үнэлгээ | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| бакалаврын болон түүнтэй адилтгах боловсролын дипломын голч дүн | магистр | боловсролын доктор | ШУ-ны доктор | туршлага | мэргэшсэн байдал | 35 оноо |
| 2.0-4.0 | 2 | 4 | 6 | 15 хүртэл | 10 хүртэл | |
| 3.48 | | | | 5 | 5 | 13.48 |

УКА0115
22

2015 оны 03 сарын 12 өдөр дугаар А/181

Улаанбаатар хот

Зэрэг дэв, түүний
нэмэгдэл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3 дах хэсэг, Улсын Их Хурлын 1995 оны "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай" 73 дугаар, 2000 оны "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журамд өөрчлөлт оруулах тухай" 20 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг нэгдүгээр хавсралтаар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг хоёрдугаар хавсралтаар, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг гуравдугаар хавсралтаар, нийслэлийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагуудын төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус олгосугай.

2. Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгохыг нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг, түүний харьяа хэлтсүүдийн дарга нарт тус тус зөвшөөрсүгэй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ Э.БАТ-ҮҮЛ

Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, төрийн хууль ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая.

Тангарагаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.

*(Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгээс)*

Тангараг өргөсөн:

2014 он 10 сар 24 өдөр

Газар (байгууллага)-ын нэр

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН**

**ТАМГЫН ГАЗАР** /БНД-ийн ЗДТГ /

овог **ХАТАНБААТАР**

нэр **БОЛОРГЭРЭЛ**

УХА0115
22

(гарын үсэг)

**ХЭНТИЙ АЙМАГ**
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 04 сарын 10 өдөр Дугаар Б/22 Чингис хот

Х.Болоргэрэлийг ажлаас чөлөөлж,
тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.1, 30 дугаар зүйлийн 30.1, Засгийн газрын 2004 оны 112 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам зүйн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн бодлого хариуцсан мэргэжилтэн Х.Болоргэрэл нь эрүүл мэндийн шалтгаанаар цаашид ажиллах боломжгүй болсон тул 2018 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөр дуусгавар болгон ажлаас чөлөөлсүгэй.

2. Х.Болоргэрэлд албан тушаалын 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж олгосугай.

3. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Г.Лхагвахатан | Нийгмийн бодлогын хэлтсийн дарга |
| Гишүүд: | Ж.Цэнджав | Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн |
| | Т.Бямбадулам | Архив, бичиг хэргийн эрхлэгч |
| | Т.Баяртуяа | Нярав |

4. Х.Болоргэрэлтэй эд хөрөнгийн тооцоог хийж дуусгахыг нярав /Т.Баяртуяа/-т, ажилласан хугацааны цалингийн болон бусад тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д тус тус даалгасугай.

ДАРГА Ж.ГАНБААТАР